



**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**

ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭЛЭЛ

Дугаар 2020/03

**Улаанбаатар хот
2020 он**

ГАРЧИГ

	Агуулга	Хуудасны дугаар
1.	Аж үйлдвэр	2
2.	Мал аж ахуй	3
3.	Хөдөө аж ахуйн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ	4

Үндэсний статистикийн хорооны албан ёсны мэдээг ашиглав.

1.АЖ ҮЙЛДВЭР



Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2020 оны эхний улирлын урьдчилсан гүйцэтгэлээр 3.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 778.3 (19.9%) тэрбум төгрөгөөр буурлаа. Үүнд уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 859.1 (29.8%) тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлөв.

Харин боловсруулах аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 23.2 (3.3%) тэрбум төгрөгөөр, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарын үйлдвэрлэл 57.6 (17.2%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл, 2020* оны эхний улиралд



Боловсруулах аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл

Бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2019		2020* он		2020* I-III 2019 I-III
		III	I-III	III	I-III	
Боловсруулах аж үйлдвэр						
Малын мах	т	1 304.5	4 547.5	260.7	1 751.0	38.5
Шингэн сүү	мян.л	3 195.1	9 399.4	3 502.9	10 515.2	111.9
Гүрил	т	14 950.0	50 227.3	16 466.6	56 352.7	112.2
Согтууруулах ундаа	мян.л	9 811.6	28 761.2	10 525.3	27 751.2	96.5
Ус, ундаа, жүүс	мян.л	26 962.6	66 257.7	41 074.2	101 430.9	153.1
Тамхи	мян.блок	302.3	784.9	-	-	-
Ноолууран сүлжмэл эдлэл	мян.ш	163.6	408.2	59.6	283.5	69.5
Самнасан ноолуур	т	26.2	99.8	10.2	74.7	74.8

2.МАЛ АЖ АХУЙ




Улсын хэмжээнд 2019 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 31.0 сая хээлтэгч малын 7.7 сая (24.7%) нь 2020 оны эхний улиралд төллөсөн байна. Эм хонины 27.6 хувь, эм ямааны 26.3 хувь, ингэний 16.4 хувь, үнээний 8.3 хувь, гүүний 2.5 хувь нь төллөжээ.

Гарсан төлийн 97.3 хувь буюу 7.4 сая төл бойжиж байна. Бойжуулсан төл өмнөх оны мөн үеэс 1.4 (23.2%) саяар өссөн байна.

Том малын зүй бус хорогдол 2020 оны эхний улиралд улсын хэмжээнд 558.1 мянга болж, өмнөх оны мөн үеэс 263.1 (89.2 хувь) мянгаар нэмэгдсэн байна. Харин 2020 оны 3 дугаар сард 384.1 мянган толгой мал хорогдсон нь эхний улиралд хорогдсон малын 68.8 хувийг эзэлж байна.

Том малын зүй бус хорогдлыг төрлөөр нь авч үзвэл, хонь 278.5 мянга, ямаа 217.9 мянга, үхэр 39.9 мянга, адуу 21.6 мянган толгой, тэмээ 178 толгой хорогдсон байна. Нийт хорогдсон малын 49.9 хувийг хонь, 39.1 хувийг ямаа эзэлж байна.

МАЛ АЖ АХУЙ, 2020 оны эхний улиралд



Хорогдсон том мал, төрлөөр, жил бүрийн эхний улирлын байдлаар

Малын төрөл	Хорогдсон том мал				Оны эхний малд том малын хорогдлын эзлэх хувь			
	2017 I-III	2018 I-III	2019 I-III	2020 I-III	2017 I-III	2018 I-III	2019 I-III	2020 I-III
	мянган толгой				хувь			
Дүн	269.0	1 116.9	295.0	558.1	0.44	1.69	0.44	0.79
Адуу	11.1	61.5	13.0	21.6	0.31	1.56	0.33	0.51
Үхэр	30.0	92.1	24.9	39.9	0.74	2.10	0.57	0.84
Тэмээ	0.1	0.6	0.3	0.2	0.02	0.13	0.06	0.04
Хонь	114.5	356.6	112.6	278.5	0.41	1.18	0.37	0.86
Ямаа	113.3	606.1	144.2	217.9	0.44	2.22	0.53	0.74

Хорогдлыг аймгаар нь авч үзэхэд 2020 оны эхний улиралд Хөвсгөл аймагт 174.8 (31.3 хувь) мянга, Архангай аймагт 164.9 (29.5 хувь) мянган толгой мал хорогдсон нь нийт хорогдлын 60.9 хувийг эзэлж байна.

Улсын хэмжээнд 2019 оны эцэст тоологдсон 31.0 сая эх малын 94.7 мянга (0.3%) нь 2020 оны эхний улиралд хорогдсон байна. Завхан, Хэнтий, Булган, Хөвсгөл, Архангай аймгуудад хээлтэгч мал 5.8- 34.8 мянгаар хорогдсон нь нийт хорогдсон хээлтэгчийн 82.1 хувийг эзэлж байна. Харин 22.6 мянган толгой хээлтүүлэгч мал хорогдсны 10.3 мянган ухна, 10.0 мянган хуц, 1.9 мянган бух, 389 толгой азарга, 17 толгой ат тус тус хорогдсон байна.

Улсын хэмжээнд 2020 оны эхний улиралд 16.4 мянган мал өвчнөөр хорогдсон байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 12.0 (3.7 дахин) мянгаар өссөн байна.

Хорогдсон нийт том малын 2.9 хувь нь өвчнөөр, 8.6 хувь нь аюулт үзэгдлээр, 88.4 хувь нь бусад буюу чоно, баавгай, ирвэс зэрэг зэрлэг амьтанд бариулах, мөсөнд цөмрөх, хад асганаас унах, өлдөх, даарах зэрэг шалтгааны улмаас хорогдсон байна.

3.ХӨДӨӨ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ДУНДАЖ ҮНЭ


Малын зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2020 оны 3 дугаар сард ат 1.0 сая төгрөг, хязаалан гуна 1.0 сая төгрөг, соёолон үрээ 873.8 мянган төгрөг, эр хонь 161.2 мянган төгрөг, эр ямаа 118.0 мянган төгрөг байна.

Нас гүйцсэн малын дундаж үнэ, жил бүрийн 3 дугаар сард, мянган төгрөгөөр




Малын аж ахуйн бүтээгдэхүүний дундаж үнийн мэдээллээр 2020 оны 3 дугаар сард цагаан ноолуурын 1 кг-ын дундаж үнэ Говьсүмбэр, Дархан-Уул, Төв аймгуудад хамгийн их буюу 70.0 мянган төгрөг, Говь-Алтай аймагт хамгийн бага буюу 42.7 мянган төгрөг байна.

Цагаан ноолуурын 1 кг-ын дундаж үнэ,
2020 оны 3 дугаар сард, аймаг, нийслэлээр, төгрөгөөр




Мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2020 оны 3 дугаар сард үхрийн 2 метрээс дээш урттай шир 4.1 мянган төгрөг, ямааны цагаан ноолуур кг-ын үнэ 58.3 мянган төгрөг байна.

Мал аж ахуйн бүтээгдэхүүний дундаж үнэ, жил бүрийн 3 дугаар сард, төгрөг



Газар тариалангийн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2020 оны 3 дугаар сард боодолтой өвсний (20кг) үнэ Дундговь аймагт хамгийн их буюу 13.5 мянган төгрөг, Дорнод аймагт хамгийн бага буюу 4.5 мянган төгрөг байна.

Боодолтой өвсний дундаж үнэ, 2020 оны 3 дугаар сард, төгрөг



Газар тариалангийн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2020 оны 3 дугаар сард 25кг хивэгний үнэ Дорноговь аймагт хамгийн их буюу 17.2 мянган төгрөг, Сэлэнгэ аймагт хамгийн бага буюу 12.7 мянган төгрөг байна.